



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 08 -р сарын 05 -ны өдөр

№ A/28-Т

Улаанбаатар хот


*Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох, дэд хороодыг байгуулах,  
тэдгээрийн гишүүдийг томилох, Төлөөлөн удирдах зөвлөлийн болон  
дэд хороодын үйл ажиллагааны журмуудыг батлах тухай*

“Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал нь Компанийн тухай хуулийн 76.1.13 дах заалт болон 81.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б. Анхболдыг томилсугай;
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх дараах байнгын үйл ажиллагаатай хороодыг байгуулсугай. Үүнд:
  - 2.1. “Аудитын хороо”;
  - 2.2. “Цалин урамшууллын хороо”;
  - 2.3. “Нэр дэвшүүлэх хороо”;
  - 2.4. “Эрсдэлийн удирдлагын хороо”
3. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг дараах бүтэцтэй томилсугай. Үүнд:
  - 3.1. “Аудитын хороо”-ны даргаар Ч. Өнөржаргалыг, хорооны гишүүдээр Ч. Хашчулуун, болон Р. Мөнхтөрийг;
  - 3.2. “Цалин урамшууллын хороо”-ны даргаар Д. Энхбатыг, хорооны гишүүдээр Т. Тэлмэн болон Ч. Өнөржаргалыг;
  - 3.3. “Нэр дэвшүүлэх хороо”-ны даргаар Ч. Хашчулууныг, хорооны гишүүдээр Д. Энхбат, болон Х. Намикиг;
  - 3.4. “Эрсдэлийн удирдлагын хороо”-ны даргаар Б. Анхболдыг, хорооны гишүүдээр Д. Баясгалан болон Г. Уянгахишигийг.
4. “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг энэхүү тогтоолын Нэгдүгээр хавсралт, “Аудитын хорооны журам”-ыг Хоёрдугаар хавсралт, “Цалин урамшууллын хорооны журам”-ыг Гуравдугаар хавсралт, “Нэр дэвшүүлэх хорооны журам”-ыг Дөрөвдүгээр хавсралт, “Эрсдэлийн удирдлагын хорооны журам”-ыг Тавдугаар хавсралтаар тус тус баталсугай;
5. Энэхүү тогтоол нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас хүчингүй болгох шийдвэр гаргах хүртэлх хугацаанд хүчинтэй байхыг тогтоосугай;
6. Компанийн бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбогдуулах 2019 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн А/07-Т тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай;

7. Энэхүү тогтоолоор батлагдсан журмуудыг Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаанд мөрдөж хэрэгжилтийг тогтмол хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга нарт даалгасугай.

Инвескор ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд:

|                                                                                     |                 |
|-------------------------------------------------------------------------------------|-----------------|
|    | Ч. Хашчулуун    |
|    | Д. Энхбат       |
|    | Ч. Өнөржаргал   |
|    | Хирохито Намики |
|    | Б. Анхболд      |
|   | Д. Баясгалан    |
|  | Р. Мөнхтөр      |
|  | Г. Уянгахишиг   |
|  | Т. Тэлмэн       |

